



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/57

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 522 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд байрлах Хандгайт өртөөнөөс Төмөртэйн орд хүртэлх төмөр зам, Хандгайт болон Төмөртэй дэх ачиж буулгах терминалыг хүлээлцэх, Төмөртэй өртөө, өртөөний барилга, оффисын барилга, зүтгүүрийн депо болон бусад барилга байгууламж, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл болон холбогдох албан хаагчдыг шилжүүлэх асуудлыг судлан дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнээр томилсугай.

Ахлагч:

Д.Нарангэрэл

Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга

Гишүүд:

Г.Бадрах

“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн Санхүүгийн удирдлагын газрын дарга

Г.Хишигбаяр

“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн Үйлдвэрлэл технологийн газрын дарга

Т.Билгээ

“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн Захиргаа удирдлагын хэлтсийн дарга

Г.Жавхлантөр

“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн Хуулийн хэлтсийн дарга

Э.Баярсайхан

“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн Захиргааны хэлтсийн дарга

Т.Цолмон

“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн Тээвэр, ложистикийн хэлтсийн дарга

М.Одонтунгалаг

“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн Төлөвлөлт, эдийн засаг, шинжилгээний Хэлтсийн ахлах мэргэжилтэн

Э.Батмаа

“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн Төмөр замын инженер

Б.Бямбабаатар

“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн Вагоны инженер

Н.Гантулга

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Хяналт хариуцсан менежер

132003307

Н.Даваажаргал	“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Санхүү хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн газрын дарга
Н.Нямболд	“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Хөрөнгийн нягтлан бодогч
Л.Эрдэнэчулуун	“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төмөртэй өртөөний нярав
Я.Ундармаа	“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Хуулийн мэргэжилтэн
Д.Нямлхагва	“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Зүтгүүрийн хэлтсийн мэргэжилтэн
Б.Мөнхбаатар	“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Вагоны хэлтсийн Техник үйлчилгээний хэсгийн мастер
Л.Мягмарсүрэн	“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Зүтгүүрийн хэлтсийн хүлээн авагч
Д.Хатанзориг	“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Дохиолол холбоо, эрчим хүчний хэлтсийн дарга
Б.Энхболд	“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Хөдөлгөөн зохион байгуулалтын хэлтсийн дарга
Б.Хүдэрхүү	“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Техникийн нөхцөл, аюулгүй ачаа, акт гомдол хариуцсан инженер
Х. Эрдэнэбаяр	“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Захиргааны асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
С.Бямбажаргал	“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Хүний нөөцийн мэргэжилтэн
А.Батмөнх	“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Барилга, автомеханик, кемп аж ахуйн албаны ахлах инженер
Д.Ганзориг	“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Ахлах механик
Б.Ганхөлөг	“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл
М.Амарсайхан	“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Хөдөлгөөн аюулгүй байдал хариуцсан ахлах байцаагч
Нарийн бичиг:	
П.Уранмандах	Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн
Б.Мөнхбаяр	“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий нягтлан бодогч бөгөөд хэлтсийн дарга
Э.Бадамрагчаа	“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Замын аж ахуйн хэлтсийн дарга


Х.Цогтбаатар

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн
Нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн дарга


2.Ажлын хэсгийн удирдамжийг хавсралтаар баталсугай.

3.Ажлын хэсгийг ажиллах нөхцөл бололцоогоор хангах, холбогдох зардлыг хариуцан ажиллахыг “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Чагнаадорж, “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал О.Батчулуун нарт даалгасугай.

4.Ажлын хэсгийн тайлан, удирдамжийн биелэлтийг 2025 оны 4 дүгээр улиралд багтаан танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (Д.Нарангэрэл)-д үүрэг болгосугай.



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн
4/37 дугаар тушаалын хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт байрлах "Монголын төмөр зам" ТӨХК-ийн эзэмшил, ашиглалтад байгаа Хандгайт өртөөнөөс Төмөртэйн орд хүртэлх төмөр зам, Хандгайт болон Төмөртэй дэх ачиж буулгах терминалыг шилжүүлэх асуудлыг судлан дүгнэлт гаргах, холбогдох хөрөнгө хүлээлцэх

Хоёр.Хамрах хүрээ

1.Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт байрлах Эдийн засаг, хөгжлийн яам болон "Кью Эс Си" ХХК-ийн хооронд байгуулсан концессын гэрээний хүрээнд бий "Монголын төмөр зам" ТӨХК-ийн эзэмшил, ашиглалтад байгаа Төмөртэй өртөөг "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн эзэмшил, ашиглалтад шилжүүлэх асуудлын хүрээнд Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд байрлах Хандгайт өртөөнөөс Төмөртэйн орд хүртэлх төмөр зам, ачиж буулгах терминалыг хүлээлцэх

2. Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд байрлах Хандгайт өртөөнөөс Төмөртэйн орд хүртэлх төмөр зам, Хандгайт болон Төмөртэй дэх ачиж буулгах терминалыг хүлээлцэх, Төмөртэй өртөө, өртөөний барилга, оффисын барилга, зүтгүүрийн депо болон бусад барилга байгууламж, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, холбогдох албан хаагчдыг шилжүүлэх асуудлыг судлан дүгнэлт гаргах

Гурав.Ажлын чиглэл

1. Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт байрлах Эдийн засаг, хөгжлийн яам болон "Кью Эс Си" ХХК-ийн хооронд байгуулсан концессын гэрээний хүрээнд бий болсон хөрөнгийг хүлээлцэх;
2. Эзэмших, ашиглах эрхийг шилжүүлсэнтэй холбоотойгоор "Монголын төмөр зам" төрийн өмчит хувьцаат компанийн холбогдох хөрөнгө, явуулж буй үйл ажиллагаа, орон тоо, ажиллагсдыг шилжүүлэх асуудлыг харилцан зөвшилцөж шийдвэрлүүлэх асуудлаар дүгнэлт гаргах
3. "Монголын төмөр зам" ТӨХК-ийн өөрийн хөрөнгөөр бий болгосон үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн судалгаа, жагсаалтыг гаргах, холбогдох орлого, зардал, гаалийн болон бусад татвар хураамжийн тооцоо судалгаа, танилцуулга бэлтгэх, дүгнэлт гаргах;

Дөрөв.Дүгнэлт

- 4.1. Ажлын хэсэг батлагдсан удирдамжийн дагуу ажиллах;
- 4.2. Дүгнэлтийг 2025 оны 4 дүгээр улиралд багтаан шийдвэрлүүлэх арга хэмжээ авах.

-----oooOOOooo-----